



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/134

Номгон

Тэжээл хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27¹.1.4, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 297 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2022 оны 13/01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 297 дугаар тогтоолын дагуу аймгийн Онцгой комиссын Төв шуурхай штабын шийдвэрээр сумдад үнэ төлбөргүй олгох тэжээлийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Онцгой комиссын Төв шуурхай штабаас батлагдсан хуваарийн дагуу дээрх тэжээлийг үнэ төлбөргүй олгож, тайлан мэдээг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн Онцгой байдлын газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үнэгүй олгох тэжээлийг зориулалтын бусаар зарцуулах, дамлан худалдах зөрчил гаргахгүй байхад онцгой анхаарч ажиллахыг аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб хариуцсан орлогч дарга, аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220329

Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын
10-ны өдрийн дүгээр захирамжийн хавсралт



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ 297 ДУГААР ТОГТООЛЫН ДАГУУ
УЛСЫН НӨӨЦИЙН САЛБАР, ЦЭГҮҮДЭЭС СУМДАД ҮНЭГҮЙ ОЛГОХ
ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

Д/д	Сумдын нэрс	УН-ийн 127-р салбар			УН-ийн 026 дугаар цэг			УН-ийн 080 дугаар цэг			УН-ийн 042 дугаар цэг			Нийт дүн
		тэжээл /ширхэгээр/	тэжээл /тонноор/	Нийт үнэ	тэжээл /ширхэгээр/	тэжээл /тонноор/	Нийт үнэ	тэжээл /ширхэгээр/	тэжээл /тонноор/	Нийт үнэ	тэжээл /ширхэгээр/	тэжээл /тонноор/	Нийт үнэ	
1	Баянхонгор сум	6	0,15	98,250										98,250
		359	8,975	6,103,000										6,103,000
		4273	106,825	75,845,750										75,845,750
2	Заг сум							43	1,075	720,250				2,395,250
								137	3,425	2,431,750				2,431,750
3	Жаргалант							100	2,5	1,675,000				
4	Бууцагаан сум				10	0,25	155,000							155,000
					180	4,5	2,947,500							2,947,500
5	Баянговь сум										464	11,6	8,236,000	8,236,000
Бүгд		4638	115,95	82,047,000	190	4,75	3,102,500	280	7,0	4,827,000	464	11,6	8,236,000	98,212,500

Жич: Улсын нөөцийн салбар, цэгүүдээс сумдад үнэгүй олгож буй тэжээлийг олгохдоо тухайн сумын албан бичиг, орлогын баримт, бусад холбогдох баримт бичгийг үндэслэн бараа материалыг олгоно.

.....оОо.....